



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/90

Номгон

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.6, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1, Улсын Онцгой комиссын 2022 оны Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуурайшилтын улирал эхэлж ой, хээрийн түймэр гарах эрсдэл үүссэнтэй холбогдуулан байгалийн дагалт нөөц баялгийг ашиглах, амралт, аялал, зугаалга болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл, 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл түр хугацаагаар хориглосугай.

2.Ой хээрийн түймэр гарах эрсдэл бүхий Баян-Овоо, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Жинст, Өлзийт, Эрдэнэцогт сумдын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.1.Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд биелэлтийг гаргаж ирүүлэх, өдөр тутамд хяналт тавих зорилгоор морьт эргүүлийг томилгоожуулан ажиллахыг Баян-Овоо сумын Засаг дарга (Ж.Хатанбаатар), Галуут сумын Засаг дарга (А.Батбаяр), Гурванбулаг сумын Засаг дарга (Б.Гантулга), Жаргалант сумын Засаг дарга (Д.Мөнхжаргал), Жинст сумын Засаг дарга (Р.Батжаргал), Өлзийт сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат), Эрдэнэцогт сумын Засаг дарга (Д.Цэвэгдорж) нарт тус тус даалгасугай.

601220223

## 2.

3. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага албан тушаалтнуудад даалгасугай. Үүнд:

3.1. Аймгийн нутаг дэвсгэрт гарсан ой хээрийн түймрийн шалтгаан нөхцөл, эзэн холбогдогчийг шуурхай илрүүлэн, ойн сан бүхий газарт явганаар болон тээврийн хэрэгслээр нэвтрэх иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, хөдөлгөөнт эргүүл гарган удирдлагаар хангаж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т,

3.2 Аймгийн нутаг дэвсгэрт гарсан ой хээрийн түймэр дээр хүн, хүч бие бүрэлдэхүүний шаардагдах техник, багаж хэрэгслээр хангах, ой хээрийн гал түймрийн мэдээ мэдээллийг Онцгой байдлын байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт мэдэгдэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн захирагч (хурандаа Ц.Батхүү)-д

3.3. Ойн сан бүхий газарт үйл ажиллагаа явуулж буй амралт, аялал жуулчлалын газруудтай хамтран иргэдийг ойн сан бүхий газарт явган аялалыг зохион байгуулахгүй байх, анхааруулга сэрэмжлүүлгийг тогтмол өгч урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-т;

3.4. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн сан бүхий газарт авто тээврийн хэрэгсэл нэвтэрч болох газруудад зурвас шуудуу гарган, автомашины саад, сэрэмжлүүлэх самбаруудыг нэмэлтээр байрлуулан, ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т,

3.5 Ой хээрийн нөхцөл байдал хүндэрч 14 хоногоос дээш хугацаагаар ажиллаж, аймгаас нэмэлт хүн хүч, дайчлан ажиллах үед бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эмнэлгийн баг томилуулан ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т,

3.6. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, ногоон бүсэд байрлах хороод, аж ахуйн нэгж байгууллагыг томилгоожуулж, эргүүл жижүүрийг тогтмол ажиллуулж ой хээрийн түймрийн үед үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийг тодотгон, шаардагдах шатахуун тослох материал, хоол хүнс, түймэр унтраах багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр мэдээллээр ханган үүнтэй холбогдон гарах зардлыг шийдвэрлэн ажиллахыг сумдын Засаг дарга нарт;


3.7. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлыг ард иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Д.Дэлгэрсайхан)-д

4. Ой хээрийн түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах 2.840.000 ( хоёр сая найман зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.


5. Ой хээрийн түймэр унтраах хүн, хүч техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж, түймэр гарсан тохиолдолд шуурхай унтрааж, холбогдох мэргэжлийн байгууллагыг удирдлагаар ханган, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/90 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт



**ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага албан тушаалтан
1	2	3	4
1	“Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх” Баянхонгор аймгийн ажиллах төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулах.	2022.02.21-ны дотор	Онцгой байдлын газрын дарга хурандаа Ж.Алтангэрэл
2	“Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх” хамтран ажиллах төлөвлөгөөг үндэслэж аймгийн Засаг даргын захирамжийг гарган хэрэгжилтэд хяналт тавин ажиллах.	2022.02.23-ны өдөр	Онцгой байдлын газрын дарга хурандаа Ж.Алтангэрэл
3	Орон нутгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээд, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Цагдаагийн газрын дарга, хурандаа Б.Оюутболд Байгаль орчны аялал жуулчлалын газрын дарга, Э.Ганзориг, Сумын Засаг дарга нар
4	Онцгой байдлын байгууллагын нийт бие бүрэлдэхүүний ой, хээрийн гал түймэр унтраах, автомашин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангах	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ж.Алтангэрэл
5	Ой хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед алба, мэргэжлийн анги нутгийн иргэдийг татан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж, шаардлагатай тохиолдолд дайчилгаа явуулж, урьдчилан сэргийлэх, авран хамгаалах,	Тухай бүр	Онцгой байдлын газрын дарга, хурандаа Ж.Алтангэрэл

1	2	3	4
	унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.		
6	Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн шалтгаан, эзэн холбогдогчийг тогтоох, энэ тухай холбогдох мэдээллийг Баянхонгор аймгийн Онцгой комисст танилцуулах. Ойн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасныг хэрэгжүүлэн ой хээрийн гал түймрийн аюултай үед ойд зорчих, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэг ажиллуулах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Цагдаагийн газрын дарга, хурандаа Б.Оюутболд
7	Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16, А10 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэх.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Цагдаагийн газрын дарга, хурандаа Б.Оюутболд
8	Онцгой байдлын байгууллагатай хамтран хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр сургалт зохион явуулж, бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник багаж хэрэгслээр хангах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Зэвсэгт хүчний 339 дүгээр цэргийн ангийн захирагч, хурандаа Ш.Батдаваа
9	Ой хээрийн гал түймрийг унтраах, алба хаагч нарыг нэмэлтээр томилж, хүч нэмэгдүүлэх.	Тухай бүр	Зэвсэгт хүчний 339 дүгээр цэргийн ангийн захирагч, хурандаа Ш.Батдаваа
10	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийг 6.10 7.9 дүгээр зүйлийн 7 дахь, 7.9 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт заасныг зөрчиж ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцож 02 албан даалгаврын биелэлтийг ханган ажиллах..	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Бямбадорж
11	Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр нэмж хийх, сумдын Засаг дарга нарын оролцоотой ажлыг зохион байгуулж ажиллах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга, Э.Ганзориг Сумдын Засаг дарга нар

1	2	3	4
12	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сумын Засаг даргын захирамжийг гарган ой, хээрийн түймэр гарах эрсдэл бүхий нутаг дэвсгэрт захирамжийн хугацаанд хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэг ажиллуулж, иргэд байгаль хамгаалагчдын оролцоотой морин эргүүл зохион байгуулах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Сумдын Засаг дарга нарт
13	Сумдын Засаг дарга нар захирамжийн хугацаанд хуурайшилтын нэн аюултай зэрэгт хүрсэн ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах, ногоон бүсэд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг хориглосон захирамж гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Сумдын Засаг дарга нарт
14	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож ой, хээрийн түймэр унтраах чиглэл бүхий 12-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй сайн дурын галын хэсэг байгуулж, сургалт, дадлага зохион байгуулан шаардагдах багаж хэрэгслээр хангаж ажиллах.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Сумдын Засаг дарга нарт
15	Ой, хээрийн түймэр унтраах багаж хэрэгслийг сум тус бүр бэлтгэн ашиглахад бэлэн байлгаж, гал түймэр унтраах багаж, хэрэгслийн судалгааг аймгийн Онцгой комисст хүргүүлэх.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Сумдын Засаг дарга нарт
16	01 албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг 06 дугаар сарын 15, 11 дүгээр сарын 25-ны өдөр тус тус Байгууллагын дарга, сумдын Засаг дарга нар Онцгой байдлын газарт ирүүлж мэдээ тайланг нэгтгэж аймгийн Онцгой комиссын даргад илтгэх хуудсаар танилцуулна.	2022.02.20- 2022.06.10 2022.09.20- 2022.11.10	Байгууллагын дарга захирал, эрхлэгч нарт

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/90 дүгээр захирамжийн хөрөдугаар хавсралт



**ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА**

**А. ШАТАХУУН**

д/д	Сумын нэр	хугацаа	Техник (нэгж)	Туулах зам (км)	Шатахуун норм (АИ-80)	Зарцуулах шатахуун	Үнэ /төгрөг/	Нийт /төгрөг/
1	2	3	4	5	6	7	8	9
1	Жаргалант	4 дүгээр сар	Фургон 44-21 БНХ	2000 км	20л	400л	2425	970.000
2	Галуут							
3	Баян-Овоо							
4	Эрдэнэцогт							
5	Өлзийт	9 дүгээр сар	Фургон 44-21 БНХ	2000 км	20л	400л	2425	970.000
6	Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар баг							
7	Гурванбулаг							
8	<b>Нийт дүн</b>			<b>4000 км</b>	<b>20л</b>	<b>800 л</b>	<b>-</b>	<b>1.940.000</b>

**Б. СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ**

д/д	Хэрэгжүүлэх ажил, үйлчилгээ	Тоо хэмжээ /ширхэг/	Үнэ /төгрөг/	Нийт /төгрөгөөр/
1	2	3	4	5
1	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг тараах материал	500	1500	750000
2	Ой хээрийн урьдчилан сэргийлэх хулдаасан хэвлэл	1	150000	150000
1	<b>Нийт дүн</b>			<b>900000</b>

**В. НЭГДСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

д/д	Зардлын нэр	Мөнгөн дүн
1	Шатахууны зардал	1.940.000
2	Сурталчилгааны ажлын зардал	750000
3	Ой хээрийн урьдчилан сэргийлэх хулдаасан хэвлэл	150000
3	<b>НИЙТ ДҮН</b>	<b>2.840.000</b>